

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА, САНГИЙН САЙД
МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ХАМТАРСАН ТУШААЛ

2024 оны ... сарын
...-ны өдөр

Дугаар

Улаанбаатар
хот

Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.1.12, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.15 дах заалт болон Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны ... дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Сангийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2023 оны 190/71/А-72 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Сэндбоксыг зохицуулалтын орчны журам”-д доор дурдсан агуулга бүхий 2.1.6, 4.1.3, 4.1.9, 5.3, 5.6, 5.18, 5.19, 6.2.5, 6.12, 6.13 дахь хэсэг, заалтыг тус тус нэмсүгэй:

“2.1.6.хүчин төгөлдөр мөрдөж буй хууль тогтоомж, зохицуулалтын шаардлагаас зайлсхийх зорилго агуулаагүй;

4.1.3. энэ журмын 2 дугаар хавсралтад заасан технологийн шаардлагыг хангасан болохыг нотлох баримт;

4.1.9.бүтээгдэхүүн, үйлчилгээг сэндбоксын орчинд туршсанаар хүлээгдэж буй үр дүн, эрх зүйн зохицуулалтын орчинд өөрчлөлт оруулах үндэслэл бүхий санал;

5.3. Оролцогч нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4.1-т заасан мэдээлэх үүрэгтэй этгээдийн адил мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиг үүргийг хэрэгжүүлнэ;

5.6. Оролцогч нь бүтээгдэхүүн, үйлчилгээний талаарх зар сурталчилгаандаа тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээ нь санхүүгийн зохицуулагч байгууллагаас зөвшөөрөл аваагүй буюу сэндбоксыг туршигдаж буй талаар заавал дурдана;

5.18. Оролцогч нь сэндбоксын туршилтын хугацаанд үйл ажиллагаагаа 3 хүртэлх сараар түр зогсоох зайлшгүй нөхцөл бүрдсэн тохиолдолд түр зогсоох хүсэлтээ үндэслэл бүхий тайлбар, хэрэглэгчтэй холбоотой санхүүгийн өр төлбөр, өргөдөл гомдлыг бүрэн шийдвэрлэсэн тухай мэдэгдлийн хамт Сэндбоксын албанд ирүүлнэ;

5.19. Оролцогчийн үйл ажиллагаагаа түр зогсоох хүсэлтэд холбогдох санал, дүгнэлтийг Сэндбоксын алба боловсруулан Зөвлөлд хүргүүлж, танилцуулна;

6.2.5.оролцогчийн үйл ажиллагаа 3 сараас дээш хугацаагаар зогссон болон цаашид үргэлжлүүлэн үйл ажиллагаа явуулах боломжгүй болсон;

6.12. Шилжилтийн хугацаа дуусгавар болох үед тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээний төрлөөс хамааран санхүүгийн зохицуулагч байгууллага нь шаардлагатай тусгай зөвшөөрөл, зөвшөөрлийг олгох эсхүл бүртгэнэ. Хэрэв тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээнд хамаарах зохицуулалтын орчин бүрдээгүй бол шаардлагатай орчин бүрдэх хүртэлх хугацаанд санхүүгийн зохицуулагч байгууллага нь түр зохицуулалтыг хэрэгжүүлж болно;

6.13. Санхүүгийн зохицуулагч байгууллага нь шаардлагатай тохиолдолд түр зохицуулалтын хүрээнд холбогдох хязгаарлалтыг тавьж болно.”

2.Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Сангийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2023 оны 190/71/А-72 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Сэндбоксыг

зохицуулалтын орчны журам”-ын 1.2, 2.1.4, 3.6.1, 4.1.7, 6.1, 6.9 дэх хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

“1.2. Сэндбоксын орчинд туршигдахаар зөвшөөрөгдсөн бүтээгдэхүүн, үйлчилгээ нь тусгай зөвшөөрөл шаардах тохиолдолд тусгай зөвшөөрөлд тавигдах шаардлагыг санхүүгийн зохицуулагч байгууллага зөвхөн өөрийн бүрэн эрхэд нийцэх хэмжээнд, сэндбокс хэрэгжих хугацаанд тухайн оролцогчийн хувьд бууруулах, эсхүл шаардлагаас чөлөөлөх байдлаар зохицуулж болно;

2.1.4. хувьцаа эзэмшигчид, эрх бүхий албан тушаалтнууд нь Эрүүгийн хуульд заасан авлига, албан тушаал, эдийн засгийн болон терроризм, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх, тэдгээрийг санхүүжүүлэх, хуурамч баримт бичиг үйлдэх, ашиглах гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй байх;

3.6.1.сэндбоксоод орох, сэндбоксын туршилтын хугацааг сунгах, сэндбоксоос гарах хүсэлтийг хүлээн авах, бүрдлийг хангуулах, магадлан шалгах, шаардлага хангасан хүсэлтэд холбогдох судалгаа, шинжилгээг гүйцэтгэж, чиглэл хариуцсан албан хаагчтай хамтран санал, дүгнэлт боловсруулан зөвлөлд танилцуулах;

4.1.7. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 14.1-т заасан дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөр;

6.1. Оролцогчийн сэндбоксоод туршиж буй бүтээгдэхүүн, үйлчилгээг туршилтын хугацаа дуусгавар болсон, оролцогч өөрийн хүсэлтээр гарах санал ирүүлсэн, эсхүл хугацаанаас өмнө гаргах нөхцөл бүрдсэн тохиолдолд сэндбоксоос гаргана;

6.9. Оролцогчийн сэндбоксын туршилт нь Зөвлөлөөр амжилттай буюу цаашид зах зээлд нэвтрэх боломжтой гэж дүгнэгдсэн тохиолдолд энэ журмын 4.3.7-д заасан төлөвлөгөөг хэрэгжүүлнэ. Тус төлөвлөгөөг хэрэгжүүлэх хугацаа нь 6 сар хүртэл байх ба Зөвлөл шаардлагатай гэж үзсэн тохиолдолд хугацааг сунгаж болно.”

3.Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Сангийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2023 оны 190/71/А-72 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Сэндбокс зохицуулалтын орчны журам”-ын 4.1.7 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

4.Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүүгийн зохицуулах хорооны Зах зээлийн судалгаа, хөгжлийн газар (Н.Оюунчимэг), Сангийн яамны Санхүүгийн бодлогын газар (Л.Сонор), Монголбанкны Төлбөр тооцооны газар (Э.Анар)-т тус тус даалгасугай.

САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ
ХОРООНЫ ДАРГА

САНГИЙН САЙД

МОНГОЛБАНКНЫ
ЕРӨНХИЙЛӨГЧ

Д.БАЯРСАЙХАН

Б.ЖАВХЛАН

Б.ЛХАГВАСҮРЭН

Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Сангийн сайд,
Монголбанкны Ерөнхийлөгчийн 2024 оныдүгээр
сарын-ны өдрийн дугаар
хамтарсан тушаалын хавсралт

СЭНДБОКС ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧНЫ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Санхүүгийн салбарт шинээр нэвтэрч буй технологид суурилсан шинэлэг бүтээгдэхүүн, үйлчилгээг Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанк /цаашид “санхүүгийн зохицуулагч байгууллага” гэх/-ны хяналт, зохицуулалт дор хязгаарлагдмал хүрээг хамарсан бодит орчинд, тодорхой цаг хугацаанд турших сэндбокс зохицуулалтын орчин /цаашид “сэндбокс” гэх/-г бий болгох, оролцогчдод тавигдах шаардлагыг тодорхойлох болон түүнтэй холбогдох бусад харилцааг энэ журмаар зохицуулна.

1.2. Сэндбоксын орчинд туршигдахаар зөвшөөрөгдсөн бүтээгдэхүүн, үйлчилгээ нь тусгай зөвшөөрөл шаардах тохиолдолд тусгай зөвшөөрөлд тавигдах шаардлагыг санхүүгийн зохицуулагч байгууллага зөвхөн өөрийн бүрэн эрхэд нийцэх хэмжээнд, сэндбокс хэрэгжих хугацаанд тухайн оролцогчийн хувьд бууруулах, эсхүл шаардлагаас чөлөөлөх байдлаар зохицуулж болно.

*/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны * дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/*

Хоёр. Тавигдах шаардлага

2.1. Сэндбоксын оролцогч нь дараах шаардлагыг хангасан байна:

2.1.1. Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээд байх;

2.1.2. сэндбоксын хугацаанд үйл ажиллагаанаас үүсэж болзошгүй эрсдэлийг нөхөн төлөх санхүү, төлбөрийн чадвартай;

2.1.3. банк, санхүүгийн байгууллагад хугацаа хэтэрсэн өр төлбөргүй;

2.1.4. хувьцаа эзэмшигчид, эрх бүхий албан тушаалтнууд нь Эрүүгийн хуульд заасан авлига, албан тушаал, эдийн засгийн болон терроризм, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх, тэдгээрийг санхүүжүүлэх, хуурамч баримт бичиг үйлдэх, ашиглах гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй байх;

*/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны * дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/*

2.1.5. хувьцаа эзэмшигчийн оруулж буй хувь нийлүүлсэн хөрөнгийн эх үүсвэр нь хууль ёсны эсэхийг тодорхойлох боломжтой байх бөгөөд татвар төлсөн;

2.1.6. хүчин төгөлдөр мөрдөж буй хууль тогтоомж, зохицуулалтын шаардлагаас зайлсхийх зорилго агуулаагүй;

*/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны * дугаар тогтоолоор нэмэлт оруулсан/*

2.2. Сэндбоксод дараах бүтээгдэхүүн, үйлчилгээг хамруулна:

2.2.1. санхүүгийн зах зээлд шинээр нэвтэрч байгаа, эсхүл ижил төстэй санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээтэй харьцуулахад санхүүгийн зах зээл болон хэрэглэгчийн хүртэх үр ашгийг нэмэгдүүлэх;

2.2.2. шинээр нэвтрүүлж буй технологи, шийдэлд холбогдох зохицуулалтын орчин бүрдээгүй, эсхүл одоо байгаа зохицуулалтын орчинд өөрчлөлт оруулах шаардлага үүссэн;

2.2.3. санхүүгийн зохицуулалтын орчинд шинээр нэвтэрч буй технологийн шийдэл буюу регтек;

2.2.4. санхүүгийн зохицуулагч байгууллага болон бодлого гаргагчдын зүгээс тодорхой асуудлыг шийдвэрлэх зорилгоор санал болгосон бүтээгдэхүүн, үйлчилгээ болон бусад.

2.3. Сэндбоксын оролцогчийн санал болгож буй бүтээгдэхүүн, үйлчилгээ нь дараах шаардлагыг хангасан байна:

2.3.1. санхүүгийн тогтвортой байдалд эрсдэл учруулахааргүй;

2.3.2. мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх чиглэлд ашиглагдах зорилго агуулаагүй;

2.3.3. санхүүгийн үйлчилгээний хүртээмж болон хэрэглэгчийн хүртэх үр ашиг, өгөөжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн;

2.3.4. хэрэгжих боломжтой байдал болон техник, эдийн засгийн үндэслэл, санхүүгийн үр ашгийн тооцоо хийгдсэн;

2.3.5. энэ журмын 2 дугаар хавсралтад заасан технологийн шаардлагыг хангасан;

2.3.6. сэндбоксын орчинд хэрэглэгчид санал болгоход бэлэн болсон, технологийн хөгжүүлэлт нь шаардлагатай хэмжээнд хийгдсэн.

2.4. Сэндбоксад дараах бүтээгдэхүүн, үйлчилгээг хамруулахгүй:

2.4.1. энэ журмын 2.3-т заасан шаардлагыг хангаагүй;

2.4.2. энэ журмын 4.1-т заасан баримт бичгийн бүрдлийг хангаагүй, эсхүл ирүүлсэн баримт бичгийг хуурамчаар бүрдүүлсэн нь тогтоогдсон.

Гурав. Сэндбоксын зөвлөл, алба

3.1. Энэ журмын хэрэгжилтийг хангуулах чиг үүрэг бүхий Сэндбоксын зөвлөл /цаашид “Зөвлөл” гэх/ болон Сэндбоксын алба байна.

3.2. Зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, үйл ажиллагаатай холбогдох харилцааг “Сэндбоксын зөвлөлийн дүрэм”-ээр зохицуулах ба уг дүрмийг санхүүгийн зохицуулагч байгууллагууд хамтран батална.

3.3. Зөвлөл нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

3.3.1. Сэндбоксын албаны санал, дүгнэлтийг үндэслэн сэндбоксын нөхцөл, хязгаарлалтыг тодорхойлж, сэндбоксад оруулах эсэх зөвлөмжийг гарган холбогдох санхүүгийн зохицуулагч байгууллагад хүргүүлэх;

3.3.2. сэндбокс дуусгавар болох үед холбогдох зөвлөмжийг гаргах;

3.3.3. сэндбоксад амжилттай туршигдсан бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэхэд шаардлагатай зохицуулалтын орчны талаарх зөвлөмж гаргах;

3.3.4. сэндбоксын үйл ажиллагаа болон технологид суурилсан ухаалаг санхүүгийн зах зээлийг хөгжүүлэхэд чиглэсэн бодлогын санал дэвшүүлэх.

3.4. Сэндбоксын албаны чиг үүргийг Санхүүгийн зохицуулах хороо хэрэгжүүлнэ.

3.5. Санхүүгийн зохицуулагч байгууллагын хууль, мэдээллийн технологийн болон тухайн салбарын бодлого, хяналтын чиглэл хариуцсан албан хаагч /цаашид “чиглэл хариуцсан албан хаагч” гэх/ нь сэндбоксад орох бүтээгдэхүүн, үйлчилгээний төрлөөс хамаарч тухай бүр Сэндбоксын албатай хамтран ажиллана.

3.6. Сэндбоксын алба нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

3.6.1. сэндбоксад орох, сэндбоксын туршилтын хугацааг сунгах, сэндбоксоос гарах хүсэлтийг хүлээн авах, бүрдлийг хангуулах, магадлан шалгах, шаардлага хангасан хүсэлтэд холбогдох судалгаа, шинжилгээг гүйцэтгэж, чиглэл хариуцсан албан хаагчтай хамтран санал, дүгнэлт боловсруулан зөвлөлд танилцуулах;

*/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны * дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/*

3.6.2. оролцогчийн сэндрбоксын хэрэгжилтийг үнэлэх гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, бизнес төлөвлөгөөтэй танилцан шаардлагатай тохиолдолд холбогдох саналыг бизнес төлөвлөгөөнд тусгуулах;

3.6.3. оролцогчдыг бүртгэн тэдгээрийн үйл ажиллагаанд чиглэл хариуцсан албан хаагчтай хамтран хяналт тавьж, зөвлөгөө өгч ажиллах;

3.6.4. сэндрбоксын үйл ажиллагаа болон технологид суурилсан санхүүгийн зах зээлийн талаар холбогдох судалгаа, шинжилгээг гүйцэтгэж, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх санал боловсруулах.

Дөрөв. Сэндрбоксад орох

4.1. Хүсэлт гаргагч нь дараах баримт бичгийг бүрдүүлж, Сэндрбоксын албанд ирүүлнэ:

4.1.1. сэндрбоксад орох хүсэлтээ илэрхийлсэн албан бичиг;

4.1.2. энэ журмын 1 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу гаргасан өргөдөл;

4.1.3. энэ журмын 2 дугаар хавсралтад заасан технологийн шаардлагыг хангасан болохыг нотлох баримт;

*/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны * дугаар тогтоолоор нэмэлт оруулсан/*

4.1.4. энэ журмын 4.3-т заасны дагуу боловсруулсан бизнес төлөвлөгөө;

4.1.5. энэ журмын 4.4-т заасны дагуу боловсруулсан эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө;

4.1.6. мэдээллийн аюулгүй байдлын журам;

4.1.7. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 14.1-т заасан дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөр;

*/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны * дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/*

~~4.1.7. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4.1 д хамааралгүй этгээдүүд бүтээгдэхүүн, үйлчилгээ, тэдгээрийг хэрэглэгчдэд хүргэх арга хэлбэр болон хэрэглэгчийг таньж мэдэх, эцсийн өмчлөгчийг тодорхойлж, эрсдэлийг бууруулахад чиглэсэн журам;~~

*/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны * дугаар тогтоолоор хүчингүй болсонд тооцсон/*

4.1.8. санхүүгийн тайлан;

4.1.9. бүтээгдэхүүн, үйлчилгээг сэндрбоксын орчинд туршсанаар хүлээгдэж буй үр дүн, эрх зүйн зохицуулалтын орчинд өөрчлөлт оруулах үндэслэл бүхий санал;

*/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны * дугаар тогтоолоор нэмэлт оруулсан/*

4.1.10. энэ журмын 2.1-д заасан шаардлагыг хангасан болохыг нотлох баримтыг хавсаргах.

4.2. Хүсэлт болон холбогдох баримт, материалууд монгол хэл дээр байна. Гадаад хэл дээрх баримт, материалуудыг баталгаат орчуулгын хамт ирүүлнэ.

4.3. Бизнес төлөвлөгөө нь дараах шаардлагыг хангасан байна:

4.3.1. хүсэлт гаргагч болон түүний санал болгож буй бүтээгдэхүүн, үйлчилгээний дэлгэрэнгүй танилцуулгыг тусгасан байх;

4.3.2. зорилго, зорилтуудыг нарийвчлан тусгасан, хэрэгжихүйц үйл ажиллагааны төлөвлөгөөтэй байх;

4.3.3. бүтээгдэхүүн, үйлчилгээ нь энэ журмын 2.3-т заасан шаардлагыг хангасан болохыг судалгаа, тооцооллын үр дүнгээр харуулж нотолсон байх;

4.3.4. бүтээгдэхүүн, үйлчилгээтэй холбогдох зах зээлийн судалгааг хийсэн байх;

4.3.5. туршигдах хугацаанд үйл ажиллагааны хэрэгжилтийг үнэлэх гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг хэмжигдэхүйц байдлаар тодорхойлох;

4.3.6. сэндрбоксоос гарах төлөвлөгөөтэй байх;

4.3.7. сэндрбокс амжилттай хэрэгжсэний дараа зах зээлд нэвтрэх шилжилтийн төлөвлөгөөтэй байх.

4.4. Эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө нь дараах шаардлагыг хангасан байна:

4.4.1. шаардлагатай тохиолдолд бүтээгдэхүүн, үйлчилгээг хүргэх хэрэглэгчдийн тоо, хамрах хүрээний хязгаарлалт, нэг хэрэглэгчдэд зөвшөөрөгдөх гүйлгээний тоо, эсхүл нэг удаагийн гүйлгээний дээд хэмжээг тогтоосон байх;

4.4.2. туршигдах хугацаанд хэрэглэгчид болон санхүүгийн зах зээлд үүсэж болзошгүй эрсдэлийг тодорхойлж, урьдчилан сэргийлэх, бууруулах, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах арга хэмжээний төлөвлөлтийг тусгасан байх;

4.4.3. эрсдэл учирсан тохиолдолд хохирол барагдуулах санхүү, төлбөрийн чадварын талаарх мэдээллийг тусгасан байх.

4.5. Сэндрбоксын алба нь хүсэлтийг хүлээн авч, хянах явцад хуулийн этгээдээс нэмэлт мэдээлэл шаардаж болно.

4.6. Сэндрбоксын алба нь бүрдэл бүрэн хүсэлт, холбогдох баримт бичгийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор сэндрбоксын шаардлагыг хангасан эсэхийг магадлан шалгана.

4.7. Хүсэлт гаргагчийн хүсэлт, холбогдох баримт бичиг нь энэ журмын хоёрдугаар бүлэгт заасан шаардлагыг хангаагүй тохиолдолд Сэндрбоксын алба нь хүсэлт гаргагчид албан бичгээр мэдэгдэж, хүсэлт гаргаагүйд тооцно.

4.8. Хүсэлт гаргагчийн хүсэлт, холбогдох баримт бичиг нь энэ журмын хоёрдугаар бүлэгт заасан шаардлагыг хангасан тохиолдолд Сэндрбоксын алба нь санал, дүгнэлтийг боловсруулан Зөвлөлд хүргүүлж, танилцуулна.

4.9. Зөвлөл нь Сэндрбоксын албаны санал, дүгнэлтийг үндэслэн сэндрбоксоор оруулах эсэх зөвлөмжийг гаргаж, санхүүгийн зохицуулах байгууллагад ажлын 10 өдрийн дотор хүргүүлнэ.

4.10. Энэ журмын 4.9-д заасан зөвлөмжийг үндэслэн тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээний төрлөөс хамааран Санхүүгийн зохицуулах хорооны дарга, эсхүл Монголбанкны Ерөнхийлөгч сэндрбоксоор оруулах эсэхийг шийдвэрлэнэ.

Тав. Сэндрбоксоор үйл ажиллагаа явуулах

5.1. Зөвлөл нь учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хэрэглэгчдийн эрхийг хамгаалах зорилгоор сэндрбоксын оролцогч /цаашид “оролцогч” гэх/-д заавал байлгах нөөц хөрөнгийн хэмжээ, хохирол нөхөн төлөхөд шаардлагатай хөрөнгийн доод хэмжээг тогтоох болон бүтээгдэхүүн, үйлчилгээг санал болгох зах зээлийн хүрээ, хэрэглэгчдийн тоо, нутаг дэвсгэр, нэг удаа, эсхүл нийт хийгдэх гүйлгээний тоо, хэмжээ зэрэгт хязгаарлалт тавьж болно.

5.2. Оролцогч нь Зөвлөлийн зөвлөмжид тусгасан шаардлага, хязгаарлалт, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг энэ журмын 4.1.4, 4.1.5-д заасан баримт, бичгүүдэд тусгаж, сэндрбоксоор оруулах шийдвэр гарснаас хойш ажлын 10 өдрийн дотор Сэндрбоксын албанд ирүүлнэ.

5.3. Оролцогч нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4.1-т заасан мэдээлэх үүрэгтэй этгээдийн адил мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

*/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны * дугаар тогтоолоор нэмэлт оруулсан/*

5.4. Оролцогч нь бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрэглэгчид санал болгохдоо санхүүгийн зохицуулагч байгууллагаас тухайн үйл ажиллагааг эрхлэх зөвшөөрөл аваагүй буюу бүтээгдэхүүн, үйлчилгээг сэндрбоксын орчинд туршиж байгаа болон учирч болох бусад эрсдэлийн талаар урьдчилан танилцуулж, хэрэглэгчтэй байгуулах гэрээнд тусгах үүрэгтэй.

5.5. Оролцогчийн хэрэглэгчтэй байгуулах гэрээ нь төөрөгдүүлэхүйц, хоёрдмол утга агуулаагүй, ойлгомжтой байх бөгөөд гэрээний нөхцөлтэй хэрэглэгч бүрэн танилцсан тухай болон энэ журмын 5.4-д заасан нөхцөлийг урьдчилан мэдэгдсэн талаар оролцогч нь харилцагчаар гарын үсэг зуруулан баталгаажуулна.

5.6. Оролцогч нь бүтээгдэхүүн, үйлчилгээний талаарх зар сурталчилгаандаа тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээ нь санхүүгийн зохицуулагч байгууллагаас зөвшөөрөл аваагүй буюу сэндрбоксад туршигдаж буй талаар заавал дурдана.

*/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны * дугаар тогтоолоор нэмэлт оруулсан/*

5.7. Оролцогч нь хэрэглэгчид болон тэдгээрт хүргэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар тогтмол бүртгэн мэдээллийн сан үүсгэж, нууцлалын аюулгүй байдлыг ханган ажиллана.

5.8. Оролцогч нь сэндрбоксын орчинд зөвхөн зөвшөөрөгдсөн бүтээгдэхүүн, үйлчилгээг туршина.

5.9. Оролцогч нь сэндрбоксад туршигдаж буй бүтээгдэхүүн, үйлчилгээний тайлан, мэдээг улирал бүрийн дараа сарын 10-ны дотор, шаардлагатай тохиолдолд бүтээгдэхүүн, үйлчилгээний онцлогоос хамааруулан сарын мэдээг дараа сарын 5-ны дотор Сэндрбоксын албанд ирүүлнэ.

5.10. Тайлан нь дараах шаардлагыг хангасан байна:

5.10.1. тайлангийн агуулга хэлбэр, бүтээгдэхүүн, үйлчилгээтэй холбоотой статистик мэдээлэл, хэмжигдэхүүнийг урьдчилан тодорхойлж, тайланг ойлгомжтой байдлаар боловсруулах;

5.10.2. туршилтын явцад гарсан гомдол маргаан болон технологийн эвдрэл, гэмтлийг тухай бүрд бүртгэж, шийдвэрлэсэн байдлыг дэлгэрэнгүй тусгах;

5.10.3. туршилтын явцад нийгэм, эдийн засаг, хууль эрх зүйн орчны өөрчлөлтөөс шалтгаалан хүндрэл бэрхшээл үүссэн бол түүнийг шийдвэрлэх хариу арга хэмжээг тусгах;

5.10.4. туршиж буй бүтээгдэхүүн, үйлчилгээтэй холбоотой орлого, үр дүнгийн дэлгэрэнгүй тайлан.

5.11. Шаардлагатай тохиолдолд Сэндрбоксын алба нь оролцогчоос ирүүлсэн мэдээ, тайланд нэмэлт тодруулга, тайлбарыг холбогдох нотлох баримтын хамт шаардаж болно.

5.12. Оролцогч нь энэ журмын 1 дүгээр хавсралтад заасан баримт бичигт өөрчлөлт орсон тохиолдолд ажлын 10 өдрийн дотор холбогдох мэдээллийг Сэндрбоксын албанд ирүүлнэ.

5.13. Оролцогчдод зайны болон газар дээрх хяналт шалгалтыг холбогдох санхүүгийн зохицуулагч байгууллагын хяналт шалгалтын нэгж хэрэгжүүлэх ба Сэндрбоксын алба хамтран оролцоно.

5.14. Сэндрбоксын үргэлжлэх хугацаа 1 жил хүртэл байх ба оролцогчийн хүсэлтийг үндэслэн 1 жил хүртэл хугацаагаар нэг удаа сунгаж болно.

5.15. Оролцогч нь сэндрбоксын үргэлжлэх хугацааг сунгах хүсэлтээ хугацаа дуусгавар болохоос 30-аас доошгүй хоногийн өмнө Сэндрбоксын албанд хүргүүлнэ.

5.16. Зөвлөл нь оролцогчийн хүсэлт, Сэндбоксын албаны санал, дүгнэлтийг үндэслэн сэндбоксад туршигдах хугацааг сунгах эсэх зөвлөмжийг ажлын 10 өдрийн дотор санхүүгийн зохицуулагч байгууллагад хүргүүлнэ.

5.17. Энэ журмын 5.16-д заасан зөвлөмжийг үндэслэн тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээний төрлөөс хамааран Санхүүгийн зохицуулах хорооны дарга, эсхүл Монголбанкны Ерөнхийлөгч сэндбоксад туршигдах хугацааг сунгах эсэхийг шийдвэрлэнэ.

5.18. Оролцогч нь сэндбоксын туршилтын хугацаанд үйл ажиллагаагаа 3 хүртэлх сараар түр зогсоох зайлшгүй нөхцөл бүрдсэн тохиолдолд түр зогсоох хүсэлтээ үндэслэл бүхий тайлбар, хэрэглэгчтэй холбоотой санхүүгийн өр төлбөр, өргөдөл гомдлыг бүрэн шийдвэрлэсэн тухай мэдэгдлийн хамт Сэндбоксын албанд ирүүлнэ.

*/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны * дугаар тогтоолоор нэмэлт оруулсан/*

5.19. Оролцогчийн үйл ажиллагаагаа түр зогсоох хүсэлтэд холбогдох санал, дүгнэлтийг Сэндбоксын алба боловсруулан Зөвлөлд хүргүүлж, танилцуулна.

*/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны * дугаар тогтоолоор нэмэлт оруулсан/*

Зургаа. Сэндбоксоос гарах

6.1. Оролцогчийн сэндбоксад туршиж буй бүтээгдэхүүн, үйлчилгээг туршилтын хугацаа дуусгавар болсон, оролцогч өөрийн хүсэлтээр гарах санал ирүүлсэн, эсхүл хугацаанаас өмнө гаргах нөхцөл бүрдсэн тохиолдолд сэндбоксоос гаргана.

*/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны * дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/*

6.2. Дараах тохиолдол нь оролцогчийг хугацаанаас өмнө сэндбоксоос гаргах үндэслэл болно:

6.2.1. бүтээгдэхүүн, үйлчилгээг гэмт хэрэг үйлдэх зорилгоор ашигласан болох нь тогтоогдсон;

6.2.2. оролцогч нь Зөвлөлийн зөвлөмжид заасан хязгаарлалтыг зөрчсөн, шаардлага, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллаагүй;

6.2.3. мэдээллийн аюулгүй байдал, нууцлалын шаардлагыг зөрчсөн, эсхүл оролцогчийн үйл ажиллагаанаас бий болсон гомдол, зөрчил, технологийн эвдрэл гэмтлийг засаж сайжруулах, учирсан хохирлыг нөхөн төлөх боломжгүй болсон;

6.2.4. оролцогч нь санхүүгийн зохицуулагч байгууллага болон хэрэглэгчид төөрөгдүүлсэн, буруу ташаа мэдээлэл өгсөн, эсхүл мэдээллийг нуун дарагдуулсан нь тогтоогдсон;

6.2.5. оролцогчийн үйл ажиллагаа 3 сараас дээш хугацаагаар зогссон болон цаашид үргэлжлүүлэн үйл ажиллагаа явуулах боломжгүй болсон;

*/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны * дугаар тогтоолоор нэмэлт оруулсан/*

6.2.6. оролцогчийн санал болгож буй бүтээгдэхүүн, үйлчилгээ нь энэ журмын 2.3-т заасан шаардлагад нийцэхгүй болсон.

6.3. Оролцогч хугацаанаас өмнө өөрийн хүсэлтээр бүтээгдэхүүн, үйлчилгээгээ гаргах хүсэлтээ Сэндбоксын албанд хүргүүлэх ба оролцогчийн хүсэлтэд үндэслэн Зөвлөл зөвлөмжийг ажлын 10 өдрийн дотор санхүүгийн зохицуулагч байгууллагад хүргүүлнэ.

6.4. Сэндбоксоос хугацаанаас нь өмнө гаргах нөхцөл бүрдсэн тохиолдолд оролцогчид урьдчилан мэдэгдэх бөгөөд оролцогч нь мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 10 өдрийн дотор холбогдох тайлбар, нотлох баримт бичгийг ирүүлнэ.

6.5. Энэ журмын 6.4-д заасан тайлбар, нотлох баримт бичгийг ирүүлээгүй тохиолдолд Сэндбоксын алба нь холбогдох санал, дүгнэлтийг гаргаж, Зөвлөлд танилцуулна.

6.6. Оролцогч сэндбоксын туршилтын хугацаа дуусгавар болох үед 30-аас доошгүй хоногийн өмнө сэндбоксоос гарах хүсэлтээ Сэндбоксын албанд хүргүүлэх ба оролцогчийн хүсэлт, Сэндбоксын албаны санал, дүгнэлтийг үндэслэн Зөвлөл зөвлөмжийг ажлын 10 өдрийн дотор санхүүгийн зохицуулагч байгууллагад хүргүүлнэ.

6.7. Зөвлөлийн зөвлөмжийг үндэслэн тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээний төрлөөс хамааран Санхүүгийн зохицуулах хорооны дарга, эсхүл Монголбанкны Ерөнхийлөгч сэндбоксоос гаргах эсэхийг шийдвэрлэнэ.

6.8. Оролцогчийн сэндбоксын туршилт нь амжилтгүй болж, сэндбоксоос гаргах шийдвэр гарсан тохиолдолд энэ журмын 4.1.5, 4.3.6-д заасан төлөвлөгөөг хэрэгжүүлэн хэрэглэгчдэд үйл ажиллагаа дуусгавар болсон талаар мэдэгдэх, хэрэглэгчийн санхүүгийн хохирлыг барагдуулах, сэндбоксын орчинд цуглуулсан хэрэглэгчдийн бүх мэдээллийг задруулахгүйгээр устгах зэрэг холбогдох арга хэмжээг нэн даруй авна.

6.9. Оролцогчийн сэндбоксын туршилт нь Зөвлөлөөр амжилттай буюу цаашид зах зээлд нэвтрэх боломжтой гэж дүгнэгдсэн тохиолдолд энэ журмын 4.3.7-д заасан төлөвлөгөөг хэрэгжүүлнэ. Тус төлөвлөгөөг хэрэгжүүлэх хугацаа нь 6 сар хүртэл байх ба Зөвлөл шаардлагатай гэж үзсэн тохиолдолд хугацааг сунгаж болно.

*/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны * дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/*

6.10. Оролцогч энэ журмын 6.9-д заасан хугацаанд Зөвлөлөөс тогтоосон нөхцөл, шаардлага, хязгаарлалтуудыг дагаж мөрдөнө.

6.11. Сэндбоксын алба, чиглэл хариуцсан албан хаагчтай хамтран сэндбоксоос гарах, эсхүл шилжих төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавина.

6.12. Шилжилтийн хугацаа дуусгавар болох үед тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээний төрлөөс хамааран санхүүгийн зохицуулагч байгууллага нь шаардлагатай тусгай зөвшөөрөл, зөвшөөрлийг олгох эсхүл бүртгэнэ. Хэрэв тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээнд хамаарах зохицуулалтын орчин бүрдээгүй бол шаардлагатай орчин бүрдэх хүртэлх хугацаанд санхүүгийн зохицуулагч байгууллага нь түр зохицуулалтыг хэрэгжүүлж болно.

*/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны * дугаар тогтоолоор нэмэлт оруулсан/*

6.13. Санхүүгийн зохицуулагч байгууллага нь шаардлагатай тохиолдолд түр зохицуулалтын хүрээнд холбогдох хязгаарлалтыг тавьж болно.

*/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны * дугаар тогтоолоор нэмэлт оруулсан/*

6.14. Оролцогч сэндбоксоос гарснаас хойш 30 хоногийн дотор Сэндбоксын албанд дараах тайланг ирүүлнэ:

6.14.1. сэндбоксоос гарах, эсхүл шилжих төлөвлөгөөнд заасан арга хэмжээний тайлан;

6.14.2. сэндбоксад оролцсоноор гарсан үр дүн, хэрэглэгчид тухайн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар хэрхэн хүлээж авсан, хэрэглэгчтэй холбоотой гомдол, маргаан сэндбоксын хугацаанд гарсан бол түүнийг хэрхэн шийдвэрлэсэн, хэрэв сэндбоксын туршилт амжилтгүй болсон бол түүний шалтгаан, үр дагаврын талаарх мэдээлэл бүхий тайлан.

Долоо. Бусад

7.1. Санхүүгийн зохицуулагч байгууллага нь сэндбоксад амжилттай туршигдсан бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэхэд шаардлагатай эрх зүйн зохицуулалтыг бий болгох талаар холбогдох төрийн байгууллагуудтай хамтран ажиллана.

7.2. Санхүүгийн зохицуулагч байгууллага нь оролцогчид болон олон нийтийг сэндбоксыг зохицуулалтын талаарх зөвлөгөө, мэдээллээр тогтмол хангаж ажиллана.

7.3. Санхүүгийн зохицуулагч байгууллага нь сэндбоксын ил тод байдал болон хэрэглэгчдийг мэдээллээр хангах үүднээс оролцогчийн нэр, үйл ажиллагааны чиглэл, бүтээгдэхүүн, үйлчилгээний танилцуулга, сэндбоксын эхлэх, дуусах хугацааг өөрийн цахим хуудсанд нийтэлсэн байна.

7.4. Сэндбоксад оролцож байгаа бүтээгдэхүүн, үйлчилгээнээс үүдэн хэрэглэгчдэд үүссэн хохирлыг оролцогч тал дангаараа хариуцна.

7.5. Санхүүгийн зохицуулагч байгууллага нь хүсэлт гаргагч болон оролцогчидтой холбоотой аливаа мэдээллийг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хадгалж, хамгаална.

Байгууллагын эрх бүхий албан тушаалтны мэдээлэл			
Овог, нэр:			
Албан тушаал:			
Эзэмшсэн боловсрол, мэргэжил:			
Холбоо барих утас:			
И-мэйл хаяг:			
Өргөдлийн маягтыг бөглөж буй ажилтны мэдээлэл			
Өргөдөл гаргаж буй ажилтны овог, нэр:			
Албан тушаал:			
Холбоо барих утас:			
И-мэйл хаяг:			
Сэндбокс үргэлжлэх хугацаанд өөр байгууллагатай хамтран ажиллах бол тухайн байгууллагын мэдээлэл			
Байгууллагын нэр, бүртгэлийн дугаар:			
Тусгай зөвшөөрөл эзэмшдэг бол тусгай зөвшөөрлийн гэрчилгээний дугаар:			
Байгууллагын хаяг:			
Холбоо барих утас:			
И-мэйл хаяг:			
Цахим хуудас:			
Үүсгэн байгуулагдсан огноо:			
Ажилчдын тоо:			
Хөрөнгө оруулалтын хэлбэр:		<input type="checkbox"/> Дотоодын хөрөнгө оруулалттай <input type="checkbox"/> Гадаадын хөрөнгө оруулалттай	
Үйл ажиллагаа явуулдаг чиглэл:			
2. СЭНДБОКСОД ОРОХ БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ, ТЕХНОЛОГИЙН ШИЙДЛИЙН ТАЛААР			

А. Сэндбоксад орох бүтээгдэхүүн, үйлчилгээ, тэдгээрийн бусдаас ялгарах онцлогийг товч тайлбарлан бичнэ үү.

Б. Сэндбоксад орох бүтээгдэхүүн, үйлчилгээнээс хүлээж буй үр дүн мөн ашиглаж буй технологи нь хөгжүүлэлтийн үе шатны аль хэсэгт явж буй талаар бичнэ үү.

В. Сэндбоксад орох бүтээгдэхүүн, үйлчилгээний шинэлэг байдал, санхүүгийн зах зээл, тэдгээрт оролцогчдын үр ашиг, өгөөжийг хэрхэн нэмэгдүүлэх талаар бичнэ үү.

Г. Сэндбоксад орох бүтээгдэхүүн үйлчилгээний өрсөлдөгчдөөс ялгарах онцлогийг бичнэ үү.

Д. Технологийн хувьд гарч болзошгүй эрсдэл, түүнээс үүдэж болох хохирлыг хэрхэн бууруулах талаар төлөвлөгөөгөө товч бичнэ үү.

Е. Сэндбоксын хүрээнд танай бүтээгдэхүүн, үйлчилгээг амжилттай хэрэгжүүлэхийн тулд зохицуулагч байгууллагын зүгээс ямар зохицуулалт хийх шаардлагатай гэж харж байна вэ?

3. СЭНДБОКСОД ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

А. Сэндбоксоод орох хэрэгцээ, шаардлагыг тодорхойлно уу.

Б. Сэндбоксо амжилттай хэрэгжсэн эсэхийг үнэлэх гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг бичнэ үү.

В. Сэндбоксоос хүлээж буй үр өгөөжийн талаар бичнэ үү.

Г. Сэндбоксоод орох бүтээгдэхүүн, үйлчилгээг хүргэх зорилтот хэрэглэгчид, зах зээлийн талаар товч бичнэ үү.

Д. Сэндбоксоос гарах төлөвлөгөөний талаар товч бичнэ үү.

Е. Хэрэв бүтээгдэхүүн үйлчилгээ сэндбоксоос амжилттай гарвал дараагийн алхам юу байх вэ?

Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Сангийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2024 оны дүгээр сарын-ны өдрийн дугаар хамтарсан тушаалаар баталсан “Сэндбокс зохицуулалтын орчны журам”-ын хоёрдугаар хавсралт

СЭНДБОКСЫН ОРОЛЦОГЧДОД ТАВИГДАХ ТЕХНОЛОГИЙН ШААРДЛАГА

Сэндбоксад оролцохоор хүсэлт гаргаж буй хуулийн этгээд нь дараах технологийн шаардлагуудыг хангасан байна:

- Хоёрдугаар түвшний (Tier 2) стандартын дата төвтэй, эсхүл энэ стандартыг хангасан дата төвд системийг байршуулсан байх;
- Хэрэглэгчийн мэдээллийг нийтийн болон хувийн сүлжээгээр дамжуулахдаа шифрлэн нууцалсан байх;
- Албан ёсны эрх бүхий вирусээс хамгаалах программ хангамж ашигладаг байх;
- Нууцлал, аюулгүй байдлын систем болон программ хангамж хөгжүүлж, ашигласан байх;
- Хэрэглэгчийн мэдээлэлд нэвтэрч буй бүх хандалтыг хянаж, бүртгэдэг байх;
- Мэдээллийн аюулгүй байдлын бодлоготой байх.

Сэндбоксад оролцохоор хүсэлт гаргаж буй хуулийн этгээд нь өөрийн санал болгож буй бүтээгдэхүүн, үйлчилгээний онцлог, технологийн шийдэлд тохируулан дараах материалуудыг Сэндбоксын албанд ирүүлнэ:

- Ашиглаж буй технологи, тоног төхөөрөмжийн жагсаалт, танилцуулга;
- Хэрэглэгч болон сервер талуудыг хамруулсан сүлжээ болон программ хангамжийн бүтэц схем (topology schema);
- Технологи хариуцсан алба, ажилчдын чиг үүрэг, танилцуулга;
- Систем хөгжүүлэлтийн зардал;
- Өгөгдлийн санд ашигласан технологийн мэдээлэл;
- Систем хооронд ашиглагдаж буй сервисийн жагсаалт;
- Систем, хэрэглэгч болон үйл ажиллагааны гарын авлагууд;
- Системийн ачаалал даах чадварын тайлан;
- Нууцлал, аюулгүй байдлыг хангах хүрээнд хийгдсэн ажлын жагсаалт;
- ~~ISO27001 стандарт эсхүл, Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээний тайлан.~~

*/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны * дугаар тогтоолоор хүчингүй болсонд тооцсон/*

Сэндбоксын оролцогч нь туршилтын хугацаанд ISO27001 стандарт эсхүл, Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг үе шаттайгаар гүйцэтгүүлэх, зохицуулалтын технологи (регтек)-ийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх үүрэгтэй.

*/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны * дугаар тогтоолоор нэмэлт оруулсан/*